




ДАМЖУУЛАХ

Сүлжээ



2005 оноос эрхлэн гаргав.

ЦДҮС ТӨХК-ИЙН ХЭВЛЭЛ
www.transco.mn

№02 (155) 2023 оны 06 сар

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ДАШДАВАА МОНГОЛ УЛСЫН АЖ ҮЙЛДВЭРИЙН ГАВЬЯАТ АЖИЛТАН ЦОЛООР ШАГНАГДЛАА



Монгол Улсад эрчим хүчний салбар үүсэж хөгжсөний түүхт 100, 101 жилийн ойгоор Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Дашдаваа Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цолоор шагнуулж, хөдөлмөр зүтгэлээ төр түмэндээ үнэлүүлээ.

Билэгтийн Дашдаваа нь 1973 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Ховд аймгийн Жаргалант сумд төрсөн. 1991 онд Налайх дүүргийн арван жилийн нэгдүгээр дунд сургууль, 1995 онд Техникийн их сургуулийн Эрчим хүчний сургууль, 2006 онд Удирдлагын академийг тус тус дүүргэж, Үйлдвэр, хотын цахилгаан хангамж мэргэжил эзэмшсэн бөгөөд техникийн болон удирдахуйн ухааны магистр, ШУТИС-ийн докторант, зөвлөх инженер юм.

Дээд сургууль төгссөнөөс хойш 1994-1999 онд ДЦС-4 ТӨХК-д цахилгаан цехийн монтер, мастер, инженер, 1999-2000 онд ДЦС-4 ТӨХК-ийн дэргэдэх МЭЗ, ЭДС ХХК-ийн инженер, 2000-2001 онд Эрчим хүчний удирдах газрын төслийн инженер, 2001-2016 онд Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК-ийн Ашиглалт, засварын албаны ахлах инженер, Дэд станцын албаны дарга, Тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер, Улаанбаатар салбарын дарга, Техникийн бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга, 2016-2018 онд ДЦС-4 ТӨХК-ийн тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер, 2019-2022 онд Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер, 2022-2023 онд тус компанийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн тус компанийн Гүйцэтгэх захирлаар томилогдсон билээ.

Эрчим хүчний салбарт тасралтгүй 29 дэх жилдээ ажиллаж байгаа тэрбээр Эрчим хүчний салбарын түүхт ойгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн 50 дугаар зарлигаар 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр “Аж үйлдвэрийн гавьяат ажилтан” цолоор шагнагдлаа.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн үе үеийн ахмад настан, ажилтан, албан хаагч нарын нэрийн өмнөөс танд баяр хүргэж, ажил хөдөлмөрт нь өндөр амжилт, амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

НҮҮР-3

КОМПАНИЙН ТЕХНИКИЙН БОДЛОГЫН
БАРИМТ БИЧГИЙГ ШИНЭЧЛЭЛЭЭ

НҮҮР-5

УЛААНБААТАР САЛБАР

НҮҮР-7

ХАНГАЙН БҮСИЙН САЛБАР

НҮҮР-9

ГОВИЙН БҮСИЙН САЛБАР

НҮҮР-11

ӨНДӨР ХҮЧДЭЛИЙН
ХАМГААЛАЛТЫН ЗУРВАСТ
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ
ЖОЛООЧ НАРТ СУРГАЛТ
ЗОХИОН БАЙГУУЛАВ.





ТӨРИЙН ДЭЭД ОДОН МЕДАЛЬ, САЛБАРЫН ШАГНАЛААР ШАГНАГДАВ

Монгол Улсад эрчим хүчний салбар үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ой 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр тохиосон. Эрчим хүчний салбарын түүхт ойгоор компанийн ахмад настнууд болон ажилтан албан хаагчдад төрийн дээд одон медаль, салбарын шагнал гардуулж баяр хүргэж хүндэтгэл үзүүлсэн юм. Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор ахмад настан Б.Нансал, Б.Мягмаржав нар шагнагдсан бол Алтан гадас одонгоор Д.Шийтэр, С.Санъяаз, Д.Галт, Н.Батсайхан, В.Гантөмөр, УБС-ын АШҮА-ны ээлжийн инженер С.Бат-Эрдэнэ нар энгэрээ мялаасан билээ. Мөн хөдөлмөрийн хүндэт медалиар ЗӨБС-ын дарга П.Ганбаяр, УБС-ын АШҮА-ны дэд станцын ашиглалтын инженер Э.Бүрэнжаргал, ЗӨБС-ын ахмад настан Ц.Чулуунбаатар, Э.Алтаннавч, Эрчим хүчний тэргүүний ажилтнаар ТБТХ-ийн системийн тооцооны инженер Ц.Номинзаяа, ХҮХ-ийн сахиул Д.Мөнх-Эрдэнэ, Стандарт хэмжил зүйн тэргүүний ажилтан цол тэмдгээр РХАХТХ-ийн тоолуур хэмжүүрийн инженер Б.Золбоо нар тус тус шагнагдлаа. Салбарын түүхт ойгоор төрийн дээд одон медаль, салбарын шагналаар шагнагдсан ахмад настнууд болон ажилтан албан хаагчиддаа компанийн хамт олны нэрийн өмнөөс халуун баяр хүргэж, ажил хөдөлмөрийн өндөр амжилт хүсье!



Төрийн дээд одонгоор шагнагдсан ахмад настнууд, компанийн удирдлагуудын хамт




Эрчим хүчний тэргүүний ажилтан тэмдгээр шагнагдсан ажилтан албан хаагчид



Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнагдсан ЗӨБС-ийн дарга П.Ганбаяр



Стандарт хэмжил зүйн тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдсан РХАХТХ-ийн тоолуур хэмжүүрийн инженер Б.Золбоо



КОМПАНИЙН ТЕХНИКИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ШИНЭЧЛЭЛЭЭ

Сүүлийн жилүүдэд улс орны эдийн засаг эрчимтэй хөгжиж, шинэ техник технологи нэвтэрч, уул уурхай, барилгын материал, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарт олон ажлууд хийгдэж байна.

Үүнтэй уялдан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", "Эрчим хүчний яамнаас боловсруулсан ирэх 12 жилийн бодлогын баримт бичиг", "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө", дамжуулах сүлжээг шинэчлэх, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх томоохон төсөл, хөтөлбөрүүд, шинэ техник технологийн хөгжилтэй уялдуулан 2023-2033 оны хооронд баримтлах компанийн техникийн бодлогын баримт бичгийг шинэчлэх ажлыг хийлээ.

Шинэчилсэн бодлогын баримт бичиг нь 10 бүлгээс бүрдсэн. Үүнд:

1. Зорилт, үндэслэл
2. Техникийн бодлогын тэргүүлэх чиглэл, зорилтууд
3. Цахилгаан дамжуулах сүлжээний өнөөгийн байдал, үйлчлэх хүрээ, техник тоноглолын судалгаа
4. Дэд станц, ЦДАШ-ын ашиглалтын түвшинг сайжруулах, шинэчлэх, өргөтгөх чиглэлээр баримтлах бодлого, зорилт
5. РХА, хоёрдогч хэлхээ, хэмжүүр тоолуурын байгууламжийн ашиглалтын түвшинг сайжруулах, шинэчлэх, өргөтгөх, чиглэлээр баримтлах бодлого, зорилт
6. Цахилгаан эрчим хүчний чанарыг сайжруулах, горимын болон РХА-н тавил тооцооны чиглэлээр
7. Мэдээллийн технологийн чиглэлээр баримтлах бодлого
8. Хяналт удирдлагын (HMI), (SCADA) системийн чиглэлээр баримтлах бодлого
9. Техникийн бодлогыг хэрэгжүүлэхэд хүний нөөцийг хөгжүүлэх, боловсон хүчнийг тогтвор сууршилтай ажиллуулах, чадавхыг сайжруулах чиглэлээр баримтлах бодлого
10. Автомашин, тусгай зориулалтын тээврийн хэрэгслийн чиглэлээр баримтлах бодлого

Дээр дурдсан техникийн бодлогын баримт бичгийн бүлэг тус бүрээр цаашид хийх ажил, компанийн албан ёсны техникийн шийдэл, үзэл баримтлалыг тусгасан. Тухайлбал:

Цахилгаан дамжуулах сүлжээний найдвартай ажиллагааг хангаж, эрчим хүчний хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай, тоноглол, ЦДАШ-д гэмтэл гаргахгүй байх, урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээ, тоноглолын төлөв, ажиллагааны цахим хяналтын системийг төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн олон улсын стандарт, менежментийн систем, тогтолцоог нэвтрүүлж, хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхыг сайжруулах, боловсон хүчнийг тогтвор сууршилтай ажиллах боломжийг сайжруулах.

Цахилгаан дамжуулах схемийн найдваржилтыг хангах, уул уурхай, эдийн засаг, үйлдвэржилт дагасан улсын хөгжлийн хөтөлбөртэй уялдан дамжуулах сүлжээг өргөтгөх, шинэчлэх төлөвлөлтийг хийж, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр энэхүү бодлогын баримт бичигт тусгагдсан техникийн шаардлага, бодлогыг баримтлан техникийн нөхцөл, ажлын зурагт тусгуулж ажиллах.

Монгол Улсын байгаль цаг уурын нөхцөлд тохирсон Олон улсын болон дотоодын стандарт, норм, дүрмийн шаардлага хангасан, инновац шингээсэн дэвшилтэт шинэ техник, технологи нэвтрүүлэх, эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлж, дамжуулалтын алдагдлыг бууруулж, боломжит хамгийн бага түвшинд хүргэх.

Компанийн бүх төрлийн мэдээ, мэдээллийг цахимжуулж, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах.

Удирдлага хяналт, холбоо, мэдээллийн системийг хөгжүүлж, биеэ даасан компанийн горим ажиллагааны хяналтын системтэй болох.

Технологийн автомат удирдлагын системийг нэвтрүүлж, Цахилгаан дамжуулах үндэсний "Ухаалаг" сүлжээ болох суурь дэд бүтцийг бүрэн байгуулах.

Оношилгоо диагностикийн дэвшилтэт техник, багаж хэрэгслийг нэвтрүүлж, таслалт хийлгүй оношлох, болзошгүй тасралт, саатлаас урьдчилан сэргийлэх, засвар үйлчилгээг оновчтой төлөвлөж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх тогтолцоог бий болгох

Байгаль орчинд ээлтэй техник тоноглол, үйлдвэрлэлийг бодлогын хувьд дэмжиж, хүлэмжийн хийг бууруулах чиглэлээр төрийн болон Дэлхийн нийтийн чиг хандлага, зорилго хөтөлбөрийг гүйцэтгэх.

Төрийн хөгжлийн бодлогоор тодорхойлсон ЦДАШ, дэд станц шинээр барих төслийг хэрэгжүүлэхэд оролцож, төрийн бодлогыг хэрэгжүүлэн, дамжуулах сүлжээг өргөтгөх, найдваржуулж, Монгол Улсын нэгдсэн цахилгаан дамжуулах сүлжээ байгуулах үндэс суурийг тавих, төрийн бодлогод тусгуулах.

Цаашдаа компани биеэ даасан хэвийн горимын хяналтын систем (SCADA)-тэй болох, шилэн кабелийн сүлжээг өргөтгөж, тоолуурын нэгдсэн сүлжээ бий болгох, оношилгоо диагностикийн иж бүрэн системийг нэвтрүүлэх, механик реле хамгаалалтын элементийн баазыг микропроцессор болгох, 110 болон 35 кВ-ын түвшинд тосон таслуур, богино холбогч (ОД КЗ) ашиглахгүй байх, 110 болон 220 кВ-ын кабель шугам бүхий дэд станцыг хүн ам ихээр сууршсан, зай талбай багатай газруудад байгуулах, трансформаторын тосны хяналтын онлайн системийг нэвтрүүлэх, Ухаалаг загвар дэд станцын төсөл хэрэгжүүлэх, дамжуулах сүлжээний онцлогийг тусгасан стандарт, нормыг бий болгох, хүчний трансформаторт засвар үйлчилгээ хийж чанарын баталгааны сертификат олгодог болох, дамжуулах сүлжээнд олон улсын стандартаас гадна хөндлөнгийн эрх бүхий байгууллагын чанарын баталгаа бүхий КЕМА буюу түүнтэй дүйцэхүйц сертификаттай тоноглолыг ашиглах, орчин үеийн эко, цахилгаан автомашин, өндөр хүчин чадал бүхий өргөх, зөөх механизм бүхий тээврийн хэрэгслийг хэрэглээнд нэвтрүүлэх зэрэг олон чухал бодлогын чанартай ажлуудыг тусгасан.

Мөн хүний нөөц, боловсон хүчний чадавхыг сайжруулах чиглэлээр дараах ажлуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн системийг компанийн хэмжээнд нэвтрүүлэх.

Шинэ бүтээл, оновчтой санал, техникийн шийдлээр эдийн засгийн үр ашигтай, бодит хэмнэлт гарсан үед уг бүтээл, санаачилгыг патентжуулах, хэмнэсэн мөнгөн дүнгийн 30 хүртэл хувиар нэг удаагийн урамшуулал олгох асуудлыг хууль, эрхзүйн хүрээнд шийдвэрлэх, дэмжих бодлого баримтална.

Компанид үр бүтээлтэй, тогтвор сууршилтай 8-аас дээш ажилласан инженер техникийн ажилтнуудаас сонгож, гадаад хэлний мэдлэгийг сайжруулах 1 жил хүртэлх хугацаатай хэлний сургалтад гадаад улс болон дотоодын шилдэг сургалтын төвд хамруулна.

Нарийн мэргэжлийн инженер техникийн ажилтнуудыг ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг өндөр хөгжилтэй орны компани, эрчим хүчний үйлдвэр, сургалтын төвд дунд, урт хугацааны буюу 1 жил хүртэлх хугацаатай суралцах, дадлага хийх, сургалтад хамруулах боломжийг бүрдүүлнэ.

Нарийн мэргэжлийн инженер техникийн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бололцоог дээшлүүлж, орон сууцны дэмжлэг олгох, цалин нэмэгдүүлэх бодлого баримтална


Чадамж, сургалтын иж бүрэн төв байгуулах ажлыг үргэлжлүүлж, төрөлжүүлэн, мэргэжлийн ажилтнуудыг чадавхжуулах ажлыг зохион байгуулах. Үүнд: Шуурхай ажиллагааны сургалтын төвийг Улаанбаатар салбар, анхдагч хэлхээний тоноглолын засварын сургалт төвийг Зүүн өмнөд бүсийн салбарт, хоёрдогч хэлхээний сургалтын төвийг Төвийн бүсийн салбарт тус тус байгуулах, өргөжүүлэх.

Түүнчлэн бүх төрлийн техникийн болон бусад мэдээ, мэдээлэл, судалгааг цахимжуулж, онлайнар хянах, харах, ашиглах боломжийг бүрдүүлнэ.


Бодлогын хүрээнд хийх ажлыг 2026 он буюу дамжуулах сүлжээ үүсэж хөгжсөний 60 жилийн ойд угтсан болон 2033 оны түвшинд хүрсэн байх үр дүн, 2038 оны ерөнхий төсөөллийг гаргасан хэмжих нэгжтэй байдлаар боловсруулж, компанийн үйлдвэрлэл техникийн зөвлөл, захирлын зөвлөлийн хурлуудаар хэлэлцүүлж, зарчмын хувьд дэмжүүлэн, гүйцэтгэх захирлын тушаалаар баталгаажуулан мөрдөж ажиллахаар болсон.

ТЕХНИКИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС

2033 ОНЫ ТҮВШИНД ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭНИЙ ХӨГЖИЛ, ӨРГӨЖИН ТЭЛЭХ ТҮВШИН



Улаанбаатар хотод 220 кВ-ын тойрог сүлжээг шинээр бий болгож, Чингис хаан олон улсын нисэх буудлыг дагасан чөлөөт бүс, дагуул хотын цахилгаан хангамжийг бүрэн шийдвэрлэсэн байна.



ГЭМТЛИЙГ БҮРЭН УСТГАЖ, ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧИНД ХОЛБОЛОО

Энэ сарын 25-ны өдрийн 18 цаг 37 минутад Булган-Хархорин чиглэлийн 110 кВ-ын 24 ширхэг тулгуур унасан. Тус гэмтлээс үүдэж Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Булган, Төв, Дундговь, Өмнөговь аймгуудын 82 сум цахилгаан эрчим хүчээр хязгаарлагдсан. Байгалийн давагдашгүй хүчин зүйл болох усархаг бороо орж, хүчтэй шуурсны улмаас үүссэн гэмтлийг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 5 салбарын 158 хүн, 40 орчим техник хэрэгсэлтэйгээр 2023.06.26-ны өдрөөс эхлэн 4 хоногийн турш 24 цагаар шуурхай ажиллан, бүрэн арилгаж 2023.06.29-ний өдрийн 20 цаг 24 минутад цахилгаан эрчим хүчинд холболоо. Гэмтэл саатлыг цаг алдалгүй сэргээн засварлах ажилд биечлэн оролцсон инженер техникийн ажилтан, албан хаагчиддаа компанийн нэрийн өмнөөс баяр хүргэж, ажлын амжилт хүсье. Мөн биднийг дэмжиж ажилласан Эрчим хүчний яам, Өвөрхангай аймгийн Хархорин сумын "Онцгой байдлын комисс", Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн "Хархорин" салбар, Булган аймгийн Гурванбулаг сумын "Засаг даргын тамгын газар"-ын хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

МОНГОЛ УЛСЫН ГАЛ ГОЛОМТ МӨНХӨД БАДРАХ БОЛТУГАЙ!

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК



ТАЛАРХАЛ

Булган-Хархорин чиглэлд байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр үүссэн гэмтэл саатлыг түргэн шуурхай сэргээн засварлахад биднийг дэмжиж хамтран ажилласан Эрчим хүчний яам, Эрчим хүчний дэд сайд М.Баярмагнай, "Диспетчерийн үндэсний төв", "Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК, тус компанийн "Баянхонгор" салбар, "Ричвелл", "MCS", "Эрчим сүлжээ" компаниуд болон Булган аймгийн Гурванбулаг сумын Засаг даргын тамгын газар, Онцгой байдлын комисс, Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газар, Өвөрхангай аймгийн Хархорин сумын Засаг даргын тамгын газар, Онцгой байдлын комисс, ЦДҮС ТӨХК-ийн Үйлдвэрчний эвлэлийн хороо, Ахмадын хороо, Захиргаа удирдлагын хэлтсийн хамт олон та бүхэнд дамжуулах сүлжээний ажилтан, албан хаагчдын нэрийн өмнөөс халуун талархал илэрхийлж, ажлын амжилт, амьдралын сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

МОНГОЛ УЛСЫН ГАЛ ГОЛОМТ МӨНХӨД БАДРАХ БОЛТУГАЙ.


ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК



Булган аймгийн Гурванбулаг сумын удирдлагууд



ҮЭХ-ны дарга Ц.Мөнхбаатар ажилчдад ажлын бээлий, мөнгөн хандив хүлээлгэн өгч байгаа нь



УЛААНБААТАР САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН III ШАТНЫ ҮЗЛЭГ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль болон холбогдох хууль эрх зүйн акт, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, ажлын байрны болон галын стандартыг хангасан байдал, галын багаж хэрэгслийн хадгалалт хамгаалалт, цахилгааны хамгаалах хэрэгслийн хадгалалт, ашиглалт, туршилтын байдлыг газар дээр нь үзэж шалгах, ажлын байрны аюул эрсдэлийг бууруулсан байдалд үзлэг хийх, түвшин тогтоох, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах дүгнэлт гаргах, аваар саатлаас урьдчилан сэргийлэх зорилгоор хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 2023 оны 2-р улирлын 3-р шатны үзлэгийг 2023 оны 5-р сард зохион байгуулсан.

болон ажилтнуудын урам зоригийг сэргээх, ажиллах эрч хүчийг нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар салбарын ажилтнуудын дунд "Гамшгаас хамгаалах дадлага" сэдэвт сургалт, тэмцээнийг 2023 оны 04 дүгээр сарын 10,11-ний өдрүүдэд БГД-ийн Онцгой байдлын Аврах 18 дугаар анги дээр амжилттай зохион байгуулсан.



Сургалт тэмцээний үеэр

ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ.

Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамнаас жил бүрийн 4 дүгээр сарыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сар болгон зарлаж, тодорхой ажлуудыг зохион байгуулав. Аяны хүрээнд 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртөж хөдөлмөрийн чадвараа болон амь насаа алдсан ажилтнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ зохион байгуулж, салбарын нийт ажилтнууд 1 минутын турш чимээгүй зогсож, 108 зул асааж хүндэтгэл үзүүлэхийн зэрэгцээ "Эрчим хүчний салбарт гарсан золгүй тохиолдлууд болон тэдгээрээс хэрхэн урьдчилан сэргийлэх тухай" сэдвээр сургалт орсон.



ГАМШГААС ХАМГААЛАХ ДАДЛАГА СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, болзошгүй аюул, гамшгийн үед ажиллах арга барил эзэмших, ажлын байрны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эсрэг тамхимын сургалтаар олсон мэдлэгээ практикт хэрэгжүүлэх

ХАМГААЛАЛТЫН ЗУРВАСЫН ДЭГЛЭМ САХИУЛАВ.

220,110,35 кВ-ын ЦДАШ, дэд станцын хамгаалалтын зурвас зөрчилтэй ААН, айл өрхүүдэд учирч болох аюул эрсдэл, Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүчний шугам сүлжээ хамгаалах дүрмийн талаар сурталчилгаа хийх, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө эрсдэх, эрчим хүчний найдвартай ажиллагаа алдагдахаас урьдчилан сэргийлж, албан мэдэгдэл хүргүүлэх төлөвлөгөө гаргаж, 2023 оны эхний 5 сарын байдлаар ЦДАШ-ын хамгаалалтын зурваст 1093 ширхэг /ААН 239, айл өрх 822/ дэд станцын хамгаалалтын зурваст 32 ширхэг /ААН 6, айл өрх 26/ албан мэдэгдэл хүргүүлсэн бөгөөд 205 зөрчил эзэнгүй, хоосон, хүлээн аваагүй шалтгаантай байна. Компанийн хэмжээнд "Хамгаалалтын зурваст дэглэм сахиулах аян"-ы хүрээнд Баянгол дүүргийн 20-р хороо Гурвалжингийн гүүрний урд хэсгийн 10 машин механизмын, ДЦС-4 ТӨХК-ийн замын урд хэсгийн 12 машин механизмын нийт 20 гаруй жолооч нарт сургалт зохион байгуулах ажлыг 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдөр амжилттай явуулж, сургалтын үеэр машин механизмын жолооч, экскаваторын операторч нарт өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамын аюул эрсдэлийг сурталчлах, урьдчилан сэргийлэх зааварчилгаа өгч, Эрчим хүчний шугам сүлжээ хамгаалах дүрмийн заалт бүхий гарын авлага тараасан. Мөн МҮОНРТ-ийн Цагийн хүрд мэдээллийн хөтөлбөрийн баг сурвалжилга авч, БГД-ийн Замын цагдаагийн 2 дугаар хэлтсийн бие бүрэлдэхүүн дэмжлэг үзүүлээ.



ДЦС-4 ТӨХК-ийн урд хэсэгт сургалт зохион байгуулж байгаа нь

ЭЭЛЖИТ БОЛОН ЭЭЛЖИТ БУС СУРГАЛТУУД ЗОХИОН БАЙГУУЛАВ.

Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос зохион байгуулсан ХАБЭА сургалтад салбарын ХАБЭА орон тооны бус зөвлөлийн 7 ажилтныг, Азийн хөгжлийн банкнаас зохион байгуулсан "Нүүлгэн шилжүүлэлт"-ийн сургалтад АШҮА-ны дарга З.Өлзийбаяр, ашиглалт хариуцсан ахлах инженер Х.Лхагвасүрэн нарыг, ДҮТ ТӨХК-д зохион байгуулсан RTDS-н сургалтад реле хамгаалалт автоматикийн инженер Э.Одбалыг, ШУТИС-ийн ЭХС дээр зохион байгуулагдсан "Эх үүсвэр ба дамжуулах сүлжээний реле хамгаалалт автоматик" сэдэвт сургалтад реле хамгаалалт автоматикийн инженер Б.Чинзоригийг, Эрчим хүчний үндэсний төв ТӨХК-аас зохион байгуулсан "Эрчим хүчний салбарын санхүү, эдийн засгийн ажилтан"-д зориулсан сургалтад СЭЗА-ны дарга бөгөөд ахлах нягтлан бодогч Б.Жавхлан, эдийн засагч Ц.Сувдмаа нарыг, цахилгааны инженерүүдэд зориулсан сургалтад АШҮА-ны ахлах бөгөөд диспетчер инженер З.Наранзул, судалгаа, тооцоо шинэчлэлтийн инженер Б.Батболд, горим тооцооны инженер Х.Дэлгэртамир, сургалт, бүтээмжийн инженер Б.Цолмончимэг нарыг хамруулсан.



Ажилд шинээр орсон ажилтнуудад зориулсан ажлын байрны чиглүүлэх сургалтыг танхимаар болон ажлын байранд тогтмол зохион байгуулж байна.



АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Системийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор ДЦС-3-ын өндөр даралтын хэсэг ЧВА-ийн үйлчлэлээр 110/10/6 кВ-ын Өмнөд дэд станцын хэрэглээг тэжээж баланслагдсан ачаалалтай байхаар горим ажиллагаанд оруулах ажлыг ДҮТ ТӨХК болон ДЦС-3 ТӨХК-тай хамтран бүрэн хийж гүйцэтгэсэн. Үүнд: 110/35/10 кВ-ын Туул дэд станцын 105,106-р шугамын АЧР-1,2 болон давтамжийн гулсалтын хурд бүхий ROCOF хамгаалалтын функцийг оруулах, 110/10/6 кВ-ын Өмнөд дэд станцын 6,10 кВ-ын гарсан шугамуудын АЧР, хүчдэл бууралтын хамгаалалтыг гаргах, 110/35/6 кВ-ын ИХБ-3-ын ЧВА-ын давтамжийн гулсалтын функцийг бүрэн шалгах зэрэг горим ажиллагаанд орох бүх бэлтгэл ажлуудыг хангасан.

маркийн хөндийрүүлэгчээр солих, шлейфийг уртасгаж, эргэлтийн өнцгийг норм хэмжээнд бариулах шийдэл гаргасан. 205,206-р АШ-ын тулгуур №9-10-н хоорондох 6 фазын утас болон аянгын троссыг буулгаж шинэ тулгуурт шилжүүлж, тулгуур №10-д OPGW-48 маркийн шилэн кабель бүхий аянгын троссонд 1ш Jointbox суурилуулж холболт хийсэн.



Багахангай дэд станцын Т-1 трансформатор солих ажил 205,206-р АШ-н ажлын явц

110/35/10 кВ-ын Багахангай дэд станцын гэмтсэн Т-1 трансформаторыг солих ажлыг зохион байгуулан хийж дууссан. ИХБ-3-аас буусан хуучин 40 МВА-н трансформаторыг зөөж суурилуулан Багахангай дүүрэг болон Мөнхийнбаянгал ХХК-ийн хэрэглэгчдийг богино хугацаанд цахилгаан эрчим хүчээр хангасан. Энэ ажлыг хийхэд Багахангай дүүргийн 35 кВ-ын АШ-аар тэжээх түр схем гаргаж хэрэглэгчдийг аль болох цөөн цагаар таслах, ИХБ-3 болон Багахангай дэд станцын ИХБ-д кран механизм багтахгүй зайгүй учир анх удаа шопал мод ашиглан зөөх аргыг хэрэглэх зэрэг шийдлүүдийг гарган амжилттай хийж дуусгасан.



Эрдэм транс ХХК-тай хийгдсэн гэрээт ажлын дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 208-р АШ, 208-р шугамын бэлтгэл хэлхээний дамжуулагч 6 утасны бэхлэгч тулгуур дээр хүчитгэх, II, III фазад ПС-120 маркийн хөндийрүүлэгч байсныг ПС-160

Засварын албаны шугамын засварын инженер М.Мөнгөн-Эрдэнийн удирдлага дор 11 ажилтны бүрэлдэхүүнтэй бригад 2023 оны 05-р сарын 08-ны өдрөөс 06-р сарын 11-ний өдрийг дуустал хугацаанд Багануур-Бөөрөлжүүт 220 кВ-ын ЦДАШ-ын барилга угсралтын ажлаар бусад салбарын ажилтнуудтай хамтран 48 ком (192 ширхэг) тулгуурын хөл, 18 анкер тулгуур босгох ажил хийж гүйцэтгэсэн.



Хөл суурилуулж байгаа нь Эхний тулгуур боссон байдал

ЦАГ ҮЕИЙН АЖЛААР

Баярын хурал зохион байгуулав Компанийн 55 жилийн ойг тохиолдуулан Улаанбаатар салбарын хэмжээнд 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр баярын хурал зохион байгуулж, төрийн одон медалиар шагнагдсан ээлжийн инженер С.Бат-Эрдэнэ, дэд станцын ашиглалтын инженер Э.Бүрэнжаргал, бичиг хэрэг, архивч Д.Хоролсүрэн нарт хүндэтгэл үзүүлж, шугамын засварын монтёр Н.Батсүх, ээлжийн инженер Б.Энэбиш, Д.Лувсанцэрэн, Ц.Ганбат нар "Эрчим хүчний тэргүүний ажилтан" цол тэмдэг,

нийлмэл реле хамгаалалт автоматикийн инженер Б.Мөнхбадрал, судалгаа тооцоо, шинэчлэлийн инженер Б.Батболд, ээлжийн инженер Е.Алтангэрэл, ээлжийн монтёр Д.Гэрэлчулуун, Э.Мөнхтулга нар Эрчим хүчний яамны "Хүндэт жуух бичиг, нэр бүхий ажилтан, ахмад настнуудад Эрчим хүчний салбарын 100 жилийн ойн медалийг салбарын удирдлагууд гардуулж, баяр хүргэв.



Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр



Олон улсын "Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тохиолдуулан Улаанбаатар салбарын Үйлдвэрчний эвлэлийн хорооноос ажилтнуудын 0-16 насны хүүхдүүдийн дунд 3 насны ангиллаар "Бидний мэдэх эрчим хүч" сэдэвт гар зургийн уралдаанд зарлаж, байр эзэлсэн хүүхдүүдэд шагнал гардуулав.



ТӨВИЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын ХАБЭА болон ХАБ-ын орон тооны бус зөвлөлөөс 2023.05.29-2023.05.30-ны өдрүүдэд “ЭРҮҮЛ АГААР - ЭРҮҮЛ АМЬДРАЛ” уриан дор Төв аймгийн Борнуур сумын нутаг дэвсгэр Аглаг бүтээлийн хийд-Дуган хад маршрутаар 10 км явган аялал зохион байгууллаа. Явган аялалд нийт 86 ажилтан хамрагдаж буухиа, азимут, багийн мэндчилгээ, багийн зохион байгуулалт чиглэл тус бүрээр хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж А.Батнасан ахлагчтай “Транзит баг” тэргүүн байр эзэллээ.



Жил бүрийн 4 дүгээр сарын 28-ны өдрийг Үйлдвэрлэлийн ослын улмаас амь үрэгдсэн ажилчдын дурсгалыг хүндэтгэх өдөр болгон дэлхий даяар тэмдэглэн өнгөрүүлдэг. Арга хэмжээний хүрээнд салбарын конторт нийт ажилтнуудад үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх танилцуулга, мэдээлэл өгөгдөж зул өргөн хүндэтгэл үзүүлж Дархан-Уул аймгийн ХХҮГ-аас зохион байгуулсан арга хэмжээнд оролцлоо.



2023.06.07-2023.06.09-ний өдрүүдэд Монгол Улсын хэмжээнд зохион байгуулагдсан гамшгаас хамгаалах Стратеги команд штабын сургалт, 2023.06.13-2023.06.17-ны өдрүүдэд Дархан-Уул аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан Гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага сургуулилтад салбарын 22 хүний бүрэлдэхүүнтэй мэргэжлийн анги 5 тээврийн хэрэгслийн хамт оролцлоо. Урьдчилсан жагсаалын бэлтгэлд 5 удаа хамрагдаж, ИА-ны дарга А.Батбаяр, АШҮА-ны дарга Б.Мөнхбаяр нар штаб дээр нийт 144 цаг байрлаж ажиллажээ.

Түлш эрчим хүчний мэргэжлийн ангид Сургуулийн удирдагч ОБГ-ын орлогч дарга бригадын генерал Б.Ууганбаяр ХАНГАЛТТАЙ ОНЦ үнэлгээ өгч дадлага, сургуулилтад идэвх санаачилгатай оролцсон АШҮА-ны дарга Б.Мөнхбаяр “ОНЦГОЙ БАЙДЛЫН ЖУУХ БИЧИГ”-ээр шагнагдав.



ЗААА-НААС ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН АЖИЛ

Эрчим хүчний 100, 101 жил Дамжуулах сүлжээ үүсэж хөгжсөний 50, 51 жилийн ойг тохиолдуулан Салбарын 42 ахмад ажилтанг Зулзагын гол амралтын газар 5 сарын 26-ны өдөр хүлээн авч уулзалт зохион байгуулах ажил хийсэн.



АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

А. ТӨЛӨВЛӨГӨӨТ ИХ БОЛОН ТЗБАХ-ЫН АЖИЛ:

1. 110/35/10кВ-ын Баруунхараа, 110/35/6 кВ-ын Зүүнхараа дэд станцын анхдагч тоноглолын хэлхээнд их засварын ажлыг графикийн дагуу бүрэн хийж гүйцэтгэсэн. Засвараар 110кВ-ын трансформаторын термосифоны филтер болон амьсгалын филтер цэнэглэж, трансформаторын РПН-ий редукторын голын жийрэг сольж, бакыг бүтэн будах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.



3. Агаарын шугамын хамгаалалтын зурвасын дэглэм сахиулах ажлын хүрээнд Салбарын харьяа 110 кВ-ын Дархан, Сүхбаатар, Хөтөл А.Б, Орхон, Баясгалант, Ерөө ЦДАШ-уудад хамгаалалтын зурвасын зөрчилтэй 49 айл өрхөд бүртгэл судалгааны ажлыг хийж байгууллагын танилцуулга, мэдэгдэх хуудас тарааж ажилласан. 2023 онд Хөтөл, Орхон, Баясгалант шугамуудад 3 айл зөрчил арилгаж, шинээр Ерөө, Сүхбаатар шугамд 9 зөрчил бүртгэгдэж нийт 55 газар зөрчилтэй. Цаашид сум орон нутгийн захиргаа, газрын алба, мэргэжлийн хяналтын газар, мөн Түгээх сүлжээ компанитай хуулийн хүрээнд хамтран ажиллах ажлыг зохион байгуулж байна.



2. 110 кВ-ын Үйлдвэр АБ АШ-ын /6,8 км-ын урттай/ хуучина аяангын троссыг буулгаж шилэн кабелиар сольж, тулгуурт шилэн кабелийг бэхлэх, шилэн кабелийн унжилт тааруулах ажлуудыг ажил гүйцэтгэх төлөвлөгөөний дагуу бүрэн хийж гүйцэтгэсэн.

Б. ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС АЖИЛ БОЛОН ГЭМТЭЛ УСТГАЛТЫН АЖИЛ

1. 2023 оны 05 сарын 5-11 хооронд Салбарын Ерөнхий инженер М.Чулуунбаатар, ЗАН-ны дарга Б.Энх-Амгалан, АШ-ын монтёр

Ш.Батдорж нар ЭХЯ-ны харьяа Салбарын хяналтын газрын ахлах мэргэжилтэн С.Алтансүх, М.Энхжаргал, ДҮТ.ТӨХК-ийн жолооч М.Сэржхорол нарын бүрэлдэхүүн нь салбарын 220 кВ-ын 208, 257, 258, 110 кВ-ын Үйлдвэр, Дархан, 113, 114, 115, 116, Хөтөл, Орхон, Сүхбаатар, Баясгалант, Ерөө-Бугант АШ-уудын нийт уртын дагууд урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийсэн. Үүнд:

220 кВ-ын 208, 257, 258, 110 кВ-ын Үйлдвэр, Дархан, 113, 114, 115, 116, Хөтөл, Орхон, Сүхбаатар, Баясгалант, Ерөө-Бугант ЦДАШ-уудын унжилт, овор хэмжилт, тасралт, гэмтэл зөрчил, шугамын бусад техникийн үзүүлэлтийг газар дээр нь үзэж, Салбарын эрчим хүч дамжуулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, ажлын бэлэн байдал, ЦДАШ-уудын техникийн паспорт, ТЗБАХ, ИЗ, УЗ-ын ажлын гүйцэтгэлийн акттай танилцсан.



2. 220 кВ-ын 208, 110 кВ-ын Хөтөл, Ерөө агаарын шугамуудын тасралтын зоонд ээлжит бус өндрийн үзлэг хийсэн. Үзлэгээр илэрсэн Хөтөл Б АШ-н Т№22-н С фазын элемент нэвт цохигдсоныг сольж, Ерөө АШ-

ын LXY-70 маягын нэвт цохигдсон болон хагарсан элемент 72 ширхгийг сольж, 208-р агаарын шугамын бохирдсон элемент угааж, Т№140-н А фазын цохигдсон элемент сольж илэрсэн гэмтлүүдийг цаг хугацаанд нь арилгах ажлыг зохион байгуулсан.


110 кВ-ын 115-р АШ-ын ээлжит бус үзлэгээр Ту№239-д 1ш, Ту№238-д 2ш, Ту№237-д 2ш, Ту№236-д 1ш, Ту№ 233-д 2ш доод талын хөл холбосон тушаа алдагдаж байхгүй болсныг илрүүлж шинээр хөндлөвч гагнаж сэргээх ажлыг хийж хэвийн болгосон.



РХАБ-Н ИХ ЗАСВАРЫН АЖЛУУД

04-р сард графикийн дагуу Аянган бэлтгэл ажлын хүрээнд дэд станцуудын цэнэг шавхагчид хэмжилт туршилт хийх, Дархан дэд станцын 110 кВ-н холболтууд, Баясгалант, Шарын гол дэд станцуудын РХАБ-н урсгал засварын ажил, Баруунхараа дэд станцын туршилт болон РХАБ-н их засварын ажлууд хийгдсэн байна.





ХАНГАЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр 04, 05, 06 дугаар саруудад дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Ээлжит шалгалт: Салбарын хэмжээнд шинээр ажилд орсон болон албан тушаал өөрчлөгдсөн 18 ажилтанд дагалдан суралцах программ гарган өгч шалгалтын комисс тухай бүрд нь шалгалтуудыг авч байна.

Наряд, шийдвэрээр хийсэн ажил: Салбарын харьяа нийт 12 дэд станцын тоног төхөөрөмжүүд болон 110кВ, 220кВ-ын ЦДАШ-уудад нарыдаар 118, шийдвэрээр 185 удаагийн ажил гүйцэтгэж, зөрчил дутагдалгүй ажиллалаа.

Ажил гүйцэтгэх бригадуудын нийт 814 ажилтанд тухайлсан зааварчилгааг өгч ажилласан байна.

Дасгал, зааварчилгааны талаар: Шинээр ажилд орсон 1 ажилтанд урьдчилсан зааварчилгаа, 13 ажилтанд ажлын байрны анхан шатны зааварчилгаа, 2857 ажилтанд өдөр тутмын зааварчилгаа, 232 ажилтанд сар бүрийн ээлжит зааварчилгаа, ээлжит бус зааварчилгааг 239 ажилтанд, тухайлсан зааварчилгааг 814 ажилтанд тус тус өгч ажилласан байна.

Салбарын АЭД, ГЭД-ыг Баянхонгор дэд станцад III/23-24-нд мөн II улирлын АЭД, ГЭД-ыг Арвайхээр дэд станцад YI/20-ны өдөр зохион байгуулж ажиллаж байна. Алба, хэсэг, дэд станцууд дээр аваар эсэргүүцэх дасгал 10 удаа хийгдэж нийт 112 ажилтан, гал эсэргүүцэх дасгал 6 удаа хийгдэж нийт 60 ажилтан, осол эсэргүүцэх дасгал 7 удаа хийгдэж нийт 82 ажилтан тус тус хамрагдсан байна.

ХАБЭА-н бүх шатны үзлэг: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны үзлэгийг давхардсан тоогоор 85 удаа хийж 157 зөрчил, II шатны үзлэгийг 20 удаа хийж 67 нэрийн зөрчлийг илрүүлэн устгах арга хэмжээг авч ажиллалаа.

ХАБЭА-н 2-р улирлын III шатны үзлэгийг алба, хэсэг дэд станцуудад хийж эхэлсэн бөгөөд салбарын ерөнхий инженер Б.Анхбаяр ахлагчтай комисс салбарын харьяа 7 дэд станцад 06 дугаар сарын 19-25-ны өдрүүдэд хийж дуусгахаар ажиллаж байна.

Бусад ажлын талаар: Хамгаалалтын зурвасын дэглэм сахиулах ажлын хүрээнд ээлжит үзлэгийн үеэр хүмүүст таниулах материал, боршюруудыг танилцуулан хүргүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн Булган - Хишиг-Өндөрийн 30км автозамын ажлын гүйцэтгэгч нартай III/31-ний өдөр салбарт уулзалт зохион байгуулж огтлолцлын цэгт IY/03-ны өдөр хэмжилтүүд хийн харилцан тохиролцож ажиллахаар болсон.

Гүйцэтгэх захирлын тушаалаар IY/21-ний өдөр салбарын ХАБЭА-н инженерээр Ж.Анхбаяр томилогдон ажлаа хүлээн авлаа.

Засварын ажлуудын бэлтгэл хангах ажлын хүрээнд шаардлагатай плакат, санамжуудыг хэвлэн бэлэн болгосон.

5 дугаар сарын 5-ны өдөр "Ногоон ариусан" ХХК-аар салбарын цайны газар, саун, склад, ОПУ, ЗРУ-д мөн Хархорины хэсэгт мэрэгчгүйтгэл, шавжгүйтгэл хийлгэлээ.

110/35/6кВ-ын Мөрөн дэд станцад галын дохиолол суурилуулах ажлыг YI/25-аас 26-ны өдрүүдэд хийсэн. Төлөвлөгөөт галын самбар, гарцын тэмдэг хийх хуваарилалтуудыг хийж алба, дэд станцуудад хүргүүлсэн.



Салбарын ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийг 5 дугаар сарын 8-ны өдөр шинэчлэн байгуулж үйл ажиллагааг нь эрчимжүүлж эхэлсэн.

Хамгаалалтын зурвасын аяны хүрээнд 110кВ-ын Хялганат-А, Б ЦДАШ-ын Т№267-268 хоорондох хогийн цэгийг шилжүүлсэн, мөн Баянхонгор ЦДАШ-ын Т№755-756 хооронд БХЭХ-ний ТП барьсныг шилжүүлэх арга хэмжээг авхуулсан бөгөөд хийгдсэн ажлын тайланг YI/12-ны өдөр ХМХ-т хүргүүлэн ажилласан.

Улс орон даяар зохион байгуулагдаж буй гамшгаас хамгаалах стратеги сургалтад YI/07-09-ний өдрүүдэд Орхон, Булган, Хөвсгөл, Архангай, Өвөрхангай аймгуудад тус бүрд ашиглалтын инженерүүд ГХШ-т орж ажилласан бөгөөд Орхон аймгийн хэмжээний сургалтад салбарын дарга штаф дээр 72 цаг байрлан үүрэг гүйцэтгэлээ. ГХШ-н дадлага сургалтад зориулж 15 цүнх, үүргэвчийг бэлтгэн, иж бүрдэлийг цуглуулж бэлэн болгон ашиглаж байна.



Сургалтын талаар:

2023.04.12-21-ний өдрүүдэд ЗӨБС-т зохион байгуулагдсан "Хуваарилах байгууламж дэд станцын ээлжийн монтер"-ын чадамжийн гэрчилгээ олгох сургалтад:

1. С.Ууганбаатар / Хялганат дэд станцын ээлжийн монтер/
2. Г.Эрхэмбаяр /Баянхонгор дэд станцын ээлжийн монтер/
3. О.Арванжин /Цэцэрлэг дэд станцын ээлжийн монтер/ нар хамрагдсан.

2023.04.24-28-ны өдрүүдэд ШУТИС ЭХС сургуулиас зохион байгуулсан "Программчлагдах логик контроллер (PLC), үйлдвэрлэлийн автоматжуулалт" сэдэвт сургалтад мэдээллийн технологи компьютерийн инженер Э.Батням;

2023.04.26,27-ны өдрүүдэд Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК Сургалт үйлдвэрлэлийн төвөөс зохион байгуулсан "Цахилгааны инженер"-үүдэд зориулсан цахим сургалтад салбарын 7 ИТА тус тус хамрагдсан.

Эрчим хүчний яамнаас ирүүлсэн мэдээлэл даалгавар 01/2023 мөрөөр нийт ажилтнуудад;

Наряд, сэлгэн залгалт хийх, тухайлсан зааварчилгаа, шуурхай ажиллагааны нэршил, шуурхай ажиллагаанд гарч байгаа зөрчил сэдвүүдээр Ж.Анхбаяр (ХАБЭА-н инженер)

Цоож хориглох плакат тавих ба авах журам сэдвээр Б.Ундрах (СБ-ийн инженер) нар ээлжит бус сургалтыг цахимаар зохион байгуулж нийт 68 ажилтан хамрагдсан байна.



АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

110/35/10 кВ-ын Хархорин дэд станцад Дэлхийн банкны төслийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй /Төсөл захиалагч Эрдэнэт-Үйлдвэр-ТӨҮГ/, /Төсөл хэрэгжүүлэгч "Richwell LLC"/, "ӨӨРӨӨ НУНТАГЛАХ ХЭСГИЙН ӨРГӨТГӨЛИЙН ГАДНА ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН ХҮРЭЭНД 110 кВ-ЫН СИСТЕМ ШИН 15МВар-ЫН ХҮЧИН ЧАДАЛТАЙ ХҮЧДЭЛ ТОХИРУУЛГЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ СУУРИЛУУЛАХ" Төслийн хүрээнд 16 МВА-ийн чадалтай 110/10 кВ-ын трансформатор, 10 кВ-ын шунтлагч реактор, 110 кВ-ын таслуур, салгуур, гүйдэл, хүчдэлийн трансформатор, 110 кВ болон 10 кВ-ын цэнэг шавхагч, аянга зайлуулагч, 10кВ-ын ячейк, тоноглолуудын удирдлага болон хамгаалалт мөн SVG төхөөрөмжийн модулууд суурилсан контейнер зэргээс бүрдсэн 110 кВ-ын нэг ком ячейк баригдсан өргөтгөлийн ажил дуусан 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр ажилд залгагдсан.




Уг төхөөрөмжийг суурилуулснаар өнөөдрийн байдлаар дараах үр дүнгүүд гарч байна. Үүнд:

2022 оны байдлаар горим тохируулах зорилгоор 2419 удаа компенсацилах төхөөрөмжийг таслаж залгасан бол тус төхөөрөмж ашиглалтад сэлгэн залгалтын тоо эрс буурч, ашиглалтын шаардлага бүрэн хангагдахаас гадна шуурхай ажиллагааны ажилчдын ажил бага хэмжээгээр ч гэсэн хөнгөвчлөгдөж найдвартай ажиллагаа дээшилсэн.

Хархорин, Арвайхээр, Баянхонгор, Цэцэрлэг дэд станцуудад 110 кВ-ын шин дээрх ачааллаас хамаарсан хүчдэлийн хэлбэлзэл харьцангуй тогтворжиж Өвөрхангай аймгийн 25186, Архангай аймгийн 9086, Баянхонгор аймгийн 11886, Төв аймгийн 1628, нийт 47786 хэрэглэгчдийн хүчдэлийн уналтын асуудал шийдэгдэж, хэрэглэгчдийг чанартай эрчим хүчээр хангах боломжийг бүрдүүлсэн.

SVG төхөөрөмж ашиглалтад орсноор салбарын хэмжээнд нийт 8 компенсацилах төхөөрөмжийг бэлтгэлд авч техникийн алдагдлыг 4, 5 дугаар сарын байдлаар өмнө оны мөн үетэй харьцуулахад 121.404мян. кВт.цаг ЦЭХ-ээр бууруулсан байна.

Техникийн алдагдлын харьцуулалт



Тус станцын дотоод хэрэгцээний хувьд өмнөх оны мөн үеэс 17.650 мян.кВт.цагаар өсөж, дамжуулалтын алдагдлын хувьд 103.754мян.кВт.цаг ЦЭХ-ээр бууруулсан үзүүлэлттэй байна.

Засварын ажлын явц:

Их засварын нийт гүйцэтгэл 73 нэр төрлийн ажлаас 14 ажил хийгдсэн 41.18 %-тай байна.

Эрдэнэт дэд станцын 35 кВ-ын РТД-20000/35У1 маркийн тосон реакторыг ВКК-6667/35 маркийн шунтлагч хуурай реактороор сольж суурилуулах ажлыг хийж гүйцэтгэн ажилд залгасан.



Булган дэд станцын 35 кВ-ын НУО-ийн РХА, хоёрдогч хэлхээний их засвар

Сансар, Хархорин дэд станцын тоноглолын иж бүрэн туршилт хэмжилтийн их завсар. Хэмжилтийн ажлын үр дүнгээр дараагийн засвар, авах арга хэмжээг тодорхойлсон.

220 кВ-ын 203, 204-р ЦДАШ-ын тулгуур, 110 кВ-ын Хишиг-Өндөр ЦДАШ-ын трасверс будаж төмөр хийцийг зэврэлтээс хамгаалах, өнгө үзэмжийг сайжруулах технологийн арга хэмжээт их засвар



Хархорин дэд станцын 10 кВ-ын 1-р секцийн тосон таслуур түүний РХА, ХТ-1-ийн их засварын ажил

Эрдэнэт дэд станцад Хялганат-А 110 кВ-ын ЭТ, ГТ, ШуС, ТойС-ын их засварын ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Урсгал засвараар: 85 нэр төрлийн ажлаас 43 нэр төрлийн ажил хийгдэж, урсгал засварын ажлын гүйцэтгэл 51,1 %-тай 220 кВ-ын 203, 204-р АШ, 110 кВ-ын Хялганат-А,Б АШ, 110 кВ-ын Насос ЦДАШ-уудын тулгуурын газардуулгын эсэргүүцэл хэмжих ажлыг тус гүйцэтгэн сайжруулах шаардлагатай тулгууруудыг тодорхойлсон.

Эрдэнэт, Хялганат, Сансар дэд станцын шитны хэмжүүр, түүний хэлхээний урсгал засварын ажлыг хийсэн.



ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАР

ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын алба, хэсэг, дэд станцуудад сар бүр батлагдсан төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа бүх төрлийн дасгалын явц, түүний чанар, зааварчилгааны мөрдөлтөд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

2023 оны эхнээс урьдчилсан зааварчилгаанд шинээр ажилд орсон 19 ажилтан, сарын давтан зааварчилгаанд 817 ажилтан, ээлжит бус зааварчилгаанд 1051 ажилтан, өдөр тутмын давтан зааварчилгаанд 10022 ажилтан давхардсан тоогоор тус тус хамрагдаад байна.

2023 оны 2-р улирлын ХАБЭА, ашиглалт засварын III шатны үзлэгийг 2023 оны 06 сарын 12-ноос 2023 оны 06 сарын 23-ны өдрүүдэд салбарын хэмжээнд зохион байгуулан илэрсэн зөрчлүүдийг арилгах хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан. 2023 оны 1-р улирлын ХАБЭА-н III шатны үзлэгийн гүйцэтгэл 98.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.



2023 оны "Хамгаалалтын зурвас"-ын дэглэм сахиулах аяны хүрээнд компанийн ерөнхий инженер Б.Эрхэмзаяагийн 2023 оны 03 сарын 14-ний өдөр ирүүлсэн удирдамжийн дагуу салбарын хэмжээнд хийгдэх 10 ажилбар бүхий төлөвлөгөөг гаргаж батлуулан 2023 оны 03 сарын 15-ны өдрөөс 05 сарын 12-ны хооронд зохион байгуулж 8 аж ахуй нэгж, 5 айл өрхөд албан шаардлага хүргүүлж ажиллахаас гадна Говьсүмбэр аймгийн засаг дарга, ИТХ-н дарга, хамгаалалтын зурвасыг зөрсөн ААНБ-н дарга удирдлагуудтай уулзалт ярилцлага зохион байгуулж, гарц шийдлийн талаар төлөвлөгөө гарган ажилласан байна.



ХАБЭА болон бусад мэргэжлийн чиглэлийн сургалт:

"Хуваарилах байгууламж, дэд станцын ээлжийн монтёр"-ын "Чадамжийн гэрчилгээ" олгох сургалт Зүүн-Өмнөд бүсийн салбарын сургалтын бааз дээр 2023.05.22-ноос 2023.05.30-ны өдрийг дуустал хугацаанд хөтөлбөр, хуваарийн дагуу зохион байгуулагдсан. Тус сургалтад 4 салбарын нийт 13 ажилтан хамрагдсан.

Хөндлөнгийн үнэлгээ, баталгаажуулалтын багт онол болон дадлага гэсэн 2 чиглэлээр 13 ажилтан шалгалт өгч бүгд хангалттай үнэлгээ авсан.

СУРГАЛТ, БҮТЭЭМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН АЖЛУУД:

ЦДҮС ТӨХК-ийн Зүүн-Өмнөд бүсийн салбарын сургалтын бааз дээр зохион байгуулагдсан "Чадамжийн гэрчилгээ" олгох сургалтууд

Компанийн 2023 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Зүүн-Өмнөд бүсийн салбарын сургалтын бааз дээр эхний хагас жилийн байдлаар "Чадамжийн гэрчилгээ" олгох 3 удаагийн сургалт амжилттай зохион байгуулагдсан. Тус сургалтад 5 салбарын нийт 40 ажилтан хамрагдсан.

д/д	Сургалтын чиглэл	ЗӨБС	УБС	ХБС	ТБС	ГБС	Бүгд
1	"Хуваарилах байгууламж дэд станцын ээлжийн монтёр"-ын чадамжийн гэрчилгээ олгох сургалт буюу "Дэд станцын үйлчилгээний монтёр мэргэшлийн II түвшин"	7	9	6	7	0	29
3	"Хуваарилах байгууламж, дэд станцын тоноглолын ашиглалт, засварын монтёр"-ын чадамжийн гэрчилгээ олгох сургалт буюу "Цахилгаан станц шугам сүлжээний төхөөрөмжийн засварчин мэргэшлийн II түвшин"	2	5	1	2	1	11
Нийт		9	14	7	9	1	40

АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Салбарын харьяа 220/110 кВ-н ЦДАШ-ын их болон урсгал засвар, гэмтэл устгах ажил, харьяа дэд станцуудын ашиглалтын түвшин дээшлүүлэх ажил, гэмтэл устгах их засварын ажлаар нэгдсэн бригадад ээлжит бус зааварчилгаа өгч салбарын ерөнхий инженер, ИТА-уудын хамт хяналт тавин ажилласан.



220 кВ-н Бөөрөлжүүт ЦДАШ-н Багц-1 барилга угсралтын ажлын хүрээнд тулгуур №4-51 хүртэлх суурийн нүх ухах ул тавих, хөл тавих, нягтруулга хийж буцаан булах засах, завсрын тулгууруудыг угсрах, чангалгаа хийж босгох, ажлыг 2023 оны 05 сарын 01-нээс 06 сарын 10-ны хугацаанд хийж гүйцэтгэх үед нийт 55 инженер техникийн ажилтан, 14 машин механизмд тогтмол хяналт тавьж нэгдсэн бригадуудад ээлжит бус зааварчилгаа өгч хяналт тавин, захиалагч талаас ирүүлсэн албан шаардлагын биелэлтийг тухай бүр гаргаж хүргүүлэн ажилласан байна.



Засварын ажлын талаар:

Он дамжин хийгдэж байгаа Чойр дэд станцын Р-1, Р-3-н радиаторыг шинээр хийх трубаг тастаж матах ажлын гүйцэтгэл 60 хувьтай хийгдэж байна. 2023 оны төлөвлөгөөт их засварын 18 ажлаас / 292,5 сая төг 12 ажил хийгдэж гүйцэтгэл 66%-тай байна. 2023 оны төлөвлөгөөт ТЗБАХ-н 16 ажлаас /1,676.6/ 4 ажил хийгдэж ажил гүйцэтгэл 25%-тай байна. Хөрөнгө оруулалтын 11 ажлаас /283,0/ 3 ажил хийгдэж гүйцэтгэл 28 %-тай байна. 2023 оны төлөвлөгөөт урсгал засварын 87 ажлаас 75 ажил хийгдэж гүйцэтгэл 87.2%-тай байна. АТД ажлаар 132 ажлаас давхардсан тоогоор 109 ажил хийгдсэн. Аянгын улирлын бэлтгэл ажлын 26 ажлаас 25 ажил хийгдэж 96%-тай байна.

ЦДҮС ТӨХК-ийн Говийн бүсийн салбарын 10 жил ой, Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 10 жилийн ой, Өмнөговь аймгийн ЭХНУ-ийн анхны дарга Ч.Халтарын нэрэмжит Өмнөд Бүсийн Эрчим Хүчний компаниудын уулзалт зөвлөгөөн, инженер техникийн ажилтнуудын ДҮТ ТӨХК-ийн 2023 оны ажил мэргэжлийн уралдаанд ХАБЭАИ С.Зоригтбаатар, Сайншанд дэд станцын РХАИ М.Төрмандах, салбарын диспетчер инженер Г.Батцэнгэл, Багануур дэд станцын ээлжийн инженер П.Баяраа нар ЦДҮС ТӨХК-ийн Зүүн-Өмнөд бүсийн салбарын ЗӨВ багаараа оролцож дэд байр эзлсэн амжилт гаргав.



ОЛОН НИЙТИЙН ЧИГЛЭЛЭЭР:


Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр салбарынхаа ажилтнуудын хүүхдүүдийн дунд Гар зургийн уралдаан, Аха, Урлагийн үзүүлбэр, тэмцээн зохион байгуулж, Хүүхдүүдээ гарын бэлэг гардуулан өгч баярлуулсан.



Монгол Улсын салбарт эрчим хүч үүсэж хөгжсөний 100, 101 жил Цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК үүсэж хөгжсөний 55 жилийн ой, Зүүн-Өмнөд бүсийн салбар үүсэж хөгжсөний 22 жилийн ойн баярын хүрээнд Эрчим хүчний Тэргүүний ажилтан-2, Эрчим хүчний Жуух бичиг-1, Сангийн яамны Тэргүүний ажилтан-1, Сангийн яамны Жуух бичиг-1 тус тус шагнагдлаа.



Алдарт эхийн I-р Одонгоор Айраг дэд станцын Ашиглалт, шуурхай үйлчилгээний инженер Төмөрбаатарын Алтанчимэг шагнагдсан байна.



ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын хэмжээнд 2023 оны 03, 04, 05, 06 дугаар сард нарыаар 168, шийдвэрээр 170 ажил хийгдсэн. Наряд, шийдвэрээр ажил гүйцэтгэхэд ажлын аюулгүй байдлыг хариуцагчид болон бригадын бүрэлдэхүүнд онцгой анхааран, шат шатны зааварчилгааг чанартай өгч, хяналт тавьж ажилласан.

Салбарын хэмжээнд 32 удаагийн дасгал зохион байгуулагдаж 281 ажилтан хамрагдсан, сарын давтан зааварчилгааг 269 хүн, тухайлсан зааварчилгааг 1873, ээлжит бус зааварчилгааг 408 хүнд өгч ажилласан байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны үзлэгийг 913 удаа хийж 55 зөрчил, II шатны үзлэгийг 42 удаа хийж 113, III шатны үзлэгийг 1 удаа хийж 57 зөрчил илрүүлэн устгаж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч ажилласан. Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг 505 удаа хийж ажилласан.

ХАБЭА-н ажлын хүрээнд 04 дүгээр сард 10 ажил төлөвлөж сарын аян зохион байгуулсан. Сарын аяны хүрээнд салбарын ХАБЭА-н орон тооны бус зөвлөл ҮЭХ-той хамтран 04 дүгээр сарын 28-ны өдөр дархлаа дэмжих зорилгоор D витамин, зөв аарцны ундааг нийт ажилтнуудад өгсөн.

2023 оны II улирлын ХАБЭА-н III шатны үзлэгийг 06 дугаар сарын 05-ны өдрөөс 06 дугаар сарын 20-ны өдрийн хооронд дүрэм журмын хэрэгжилт, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн ажил, ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн ашиглалт, техникийн бичиг баримт бүрдүүлэлт, хөтлөлт, өндрийн ажлын аюулгүй ажиллагаа, галын аюулгүй байдал, дотоод хяналт /нарядын системийн мөрдөлт, СЗ-н хуудсын ашиглалт, ША-ны схем/ зэргийг шалгаж, дэд станцын анхдагч хэлхээний тоноглолуудад үзлэг хийж, үүрэг даалгавар өгч, ажилтнуудын санал хүсэлтийг авч, зөвлөгөө өгч ажилласан.

Өмнө I улирлын үзлэгээр илэрсэн зөрчлийг арилгасан байдал, өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангалтгүй түвшинд байна гэж комисс дүгнэсэн. Иймд алба, хэсэг, дэд станцуудын дарга, ахлах инженерүүд II улирлын үзлэгийн зөрчил арилгах, үүрэг даалгавар биелүүлэх ажлын төлөвлөгөөг дэлгэрэнгүй, хариуцах албан тушаалтныг тодорхой зааж, биелэлтийг цаг хугацаанд нь зураг, материалаар баяжуулан, дэлгэрэнгүй гаргаж ажиллахыг анхааруулж байна.



СУРГАЛТ ДАДЛАГАЖУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Монголын өндрийн ажил мэргэжлийн холбоотой хамтран 2023 оны 04 дүгээр сарын 04-05-ны өдрүүдэд "Өндөрт ажиллах үеийн аюулгүй ажиллагаа, арга техник, авраа аргачлал" сургалтыг зохион байгуулсан. Сургалтыг Монголын өндрийн ажил мэргэжлийн холбооны инженер багш Лхагвасүрэн нийт 16 цагийн онол, практик хосолсон хичээлийг зааж, шалгалтыг авсан. Сургалтад засварын албаны М.Даваадорж, И.Эрдэнэсоёл, П.Отгонтөгс, Н.Гомбодорж, Э.Энхмөнх нар хамрагдаж, шалгалтаа амжилттай үнэлгээтэй өгч, гэрчилгээг гардан авсан.



Өргөх зөөх машин механизмын сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан. Сургалтыг 8 цагийн хөтөлбөрөөр Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн Сургалт үйлдвэрлэлийн төвийн инженер багш Ч.Ванданням зааж, төстийн шалгалтыг авсан. Эрх сунгах, эрх авах 10 ажилтан хамрагдаж, шалгалтаа амжилттай өгч, мэргэжлийн үнэмлэхээ авсан.

Хуваарилах байгууламж, дэд станцын тоноглолын засварын монтёрын эрх сунгах сургалт 2023 оны 03 дугаар сарын 13-наас 03 сарын 24-ний өдрүүдэд ЗӨБС-н сургалтын бааз дээр зохион байгуулагдсан.

Тус сургалтад засварын албаны дэд станцын засварын монтёр А.Дорждэрэм хамрагдаж 10 хоногийн хугацаанд онол болон ур чадварын 2 чиглэлд шалгалтыг хангалттай үнэлгээтэй өгсөн.

Салбарын шуурхай ажиллагааны ажилтнуудын уулзалт сургалтыг зохион байгуулав.

Салбарын шуурхай ажиллагааны ажилтнуудын мэдлэгийг бататгах, мэргэжлийн ур чадварыг ахиулах, шинэ ажилтнуудыг дадлагажуулах зорилгоор уулзалт сургалтыг зохион байгуулсан. Тус уулзалт сургалтад салбарын шуурхай ажиллагааны 38 ажилтан хамрагдаж 2023 оны ИЗ, ТЗБАХ, УЗ-ын ажлууд эхлэхтэй холбогдуулан урьдчилан сэргийлэх, зөрчил гаргахгүй ажиллах зорилгоор засварын ажлын захиалга хүлээн авах, дамжуулах, батлуулах, Эрчим хүчний салбарын хэмжээнд 2016 оноос хойш гарсан сэрэмжлүүлэх мэдээлэл даалгавар, Говийн бүсийн салбарын хэмжээнд 2016 оноос хойш гарсан зөрчлүүд, ША-ны журнал бичиг баримтын хөтлөлт, техник мэдээллийн нэгдсэн сангийн баяжилт, хяналт мэдээллийн системийн мөрдөлтийг сайжруулах, мэдээ мэдээллийг түргэн шуурхай үнэн зөв дамжуулах сэдвүүдийн хүрээнд явуулж, зөвлөмж боловсруулсан. Уулзалт сургалтын үеэр компанийн ерөнхий инженер Б.Эрхэмзаяа болон бусад албаны хүмүүс ирж, шуурхай ажиллагааны ажилтнуудад зөвлөгөө өгсөн.

ЭХЯ-ны а/1094 дугаар бүхий албан бичгийн мөрөөр салбарт хийгдэх ажлын төлөвлөгөөний дагуу 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Дундговь аймгийн онцгой байдлын газартай хамтран нийт ажилтнуудад "Галын аюулгүй байдлыг хангах, галын аюулаас урьдчилан сэргийлэх" сургалтыг зохион байгуулж, ажилтнуудыг танхимаар болон зоом-р хамруулсан. Сургалтад нийт 52 ажилтан хамрагдсан.

ЭХЯ-ны мэдээлэл даалгавар 01/2023-ын мөрөөр салбарт хийгдэх ажлын төлөвлөгөөний дагуу 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр "Цоож хориглох плакат тавих ба авах журам, хүчдэлтэй байгаа гүйдэл дамжуулах хэсэгт ойртож болох зайн хэмжээ"-ний талаарх сургалтыг Сургалт бүтээмжийн инженер Н.Эрдэнэбархас зааж, танхимаар 27 ажилтан, зоом-р 25 ажилтанг хамруулсан.

2023 оны 05 дугаар сарын 22-ны өдөр "Говийн бүсийн салбарт гарсан зөрчлүүд" сэдвийн хүрээнд АШҮА-ны дарга Ч.Сугиртогтох нийт ажилтнуудад 1.5 цагийн сургалтыг заасан.

Жайка Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагаас Монгол Улсад хэрэгжүүлж буй "Сэргээгдэх эрчим хүчний оролцоо ихтэй эрчим хүчний системийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэх" төслийн хүрээнд 2023 оны 06 дугаар сарын 11-ний өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 24-ний өдрийг дуустал хугацаанд Япон Улсад зохион байгуулагдах SWG-4,5,6 /РХА, шугам, дэд станц/ багийн сургалтад РХА-н инженер Л.Энх-Амгалан хамрагдсан.

ЭХҮТ ТӨХХК-ийн Сургалт үйлдвэрлэлийн төвд "Эрчим хүчний салбарын сургалтын инженер, мэргэжилтэн нарт зориулсан сургалтад 2023 оны 06 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд Сургалт бүтээмжийн инженер Н.Эрдэнэбархас хамрагдсан.



АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

МАК ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 221.222-р АШ-н хулгайд алдагдсан деталиудыг нөхөж хийх, тулгуурын газардуулга ил гарсан болон салсан гэмтэл устгах ажлыг 2023 оны 03 сарын 29-ний өдөр шугамын засварын мастер Б.Лхагвасүрэнгээр ахлуулсан 7 хүний бүрэлдэхүүнтэй бригад, 2 машин механизмтай хийж гүйцэтгэсэн.

110/35/10 кВ Мандалговь дэд станцын Т-1 трансформаторыг Багахангай дэд станцад шилжүүлэх ажлыг 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн наряд №22-р захиалга №42-р Улаанбаатар салбар болон Говийн бүсийн салбарын засварын бригад 20 хүний бүрэлдэхүүнтэй 5 машин механизмтай хийж гүйцэтгэсэн.



Урсгал засварын ажлаар:
110/35/10 кВ-н Даланзадгад дэд станцын урсгал засварын ажлыг 2023 оны 05 сарын 03-05 -ны өдрүүдэд засварын албаны дарга О.Хоринтаванаар ахлуулсан 8 хүний бүрэлдэхүүнтэй бригад хийж гүйцэтгэсэн. 220/110/35/10 кВ-н Тавантолгой дэд станцын урсгал засварын ажлыг 2023 оны 05 сарын 08,12-ны өдрүүдэд засварын албаны дарга О.Хоринтаванаар ахлуулсан 13 хүний бүрэлдэхүүнтэй бригад хийж гүйцэтгэсэн.

Цаг үеийн ажлаар:
Салбарын 10 жилийн ойг угтаж 220/110/35/10 кВ Тавантолгой дэд станцыг жишиг станц болгох зорилгоор тохижилтын ажлыг салбарын нийт ажилтнууд 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс 21-ний өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Говийн нөхцөлд шороон шуурга ихтэй элсний нүүдэл үүссэнтэй холбоотой 0.12 га талбайд Хайлаас, Сухай, Буйлс гэсэн 3-н нэр төрлийн нийт 700 ш мод тарьж усалгааны систем суурилуулсан.

220/110/35/10 кВ-н Тавантолгой дэд станцын ажилтнуудыг уртын ээлжийн горимд оруулсантай холбогдуулан дэд станцын удирдлагын байрнаас ажилтнуудын байр хүртэл явган зам тавих, гэрэлтүүлэг хийх

ажил хийгдсэн. Нийт 103 метр газар явган зам суурилуулж, 400 Вт-н чадалтай нараар цэнэглэгддэг 3-н горимд ажилладаг 4 ширхэг гэрэлтүүлэг суурилуулсан.

Дэд станцын машин ордог гол хаалганд удирдлагатай гүйдэг хаалга шинээр хийсэн. Тавантолгой дэд станцын өнгө үзэмжийг сайжруулж кабелийн лоткины тагийг будгаар будах ажил хийсэн.

Мөн дээрх өдрүүдэд 220/110/35/10 кВ-н Тавантолгой дэд станцын хашаа болон тоноглол, лоткинд шуурсан элсийг 10 механизм бүхий 58 ажилтны бүрэлдэхүүнтэй бригад цэвэрлэсэн. 35 кВ-н ИХБ-н 65 метр, 110 кВ-н ИХБ-н 464 метр лоткины дотор элсийг гаргаж, лоткины ханыг дагаж шуурсан гадна элсийг зөөсөн. 220 кВ-н ИХБ-н 815,4 метр лоткины гадна шуурсан элс болон талбайн элсийг зөөж цэвэрлэсэн. Дэд станцын хашаанд шуурсан элс, хуучин тарьсан модны орчмын элсийг зөөж холдуулах ажлыг унагалдай-1, ковш-2, хово самосвол-3 автомашинаар 3 хоногийн хугацаанд хусаж, ачиж, зөөж асгасан. Уг талбайгаас нийт 250 хово буюу 5000тн орчим элсийг зөөж зайлуулсан. Дэд станцын хашаанд хургах элсний нүүдлийг тогтоон барих зорилгоор станцын хашааны

гадна салхин талд том оврын автомашины хуучин хаягдал 860 ширхэг дугуйгаар хүрээ босгосон.



Шуурхай ажиллагааны ажилтнуудын уулзалт зөвлөгөөн, ажил мэргэжлийн уралдаан зохион байгууллаа.






ТӨВ УДИРДЛАГА

МОНГОЛ УЛСЫН ОЮУ ТОЛГОЙ ТӨСӨЛД ЗОРИУЛЖ
ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ ХУДАЛДАН АВАХ, ХУДАЛДАХ
ТУХАЙ ГЭРЭЭНИЙ “НЭМЭЛТ ГЭРЭЭ”-Г БАЙГУУЛАВ.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК, Өвөр Монголын Эрчим Хүчний Олон Улсын Хамтын Ажиллагааны компанитай 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр “Монгол Улсын Оюу толгой төсөлд зориулж цахилгаан эрчим хүч худалдан авах, худалдах тухай гэрээний “Нэмэлт гэрээ”-г байгуулж, гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацааг сунгасан юм. Өвөр Монголын Эрчим Хүчний Олон Улсын Хамтын Ажиллагааны компанийг төлөөлж тус компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Жао Чанг, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийг төлөөлж гүйцэтгэх захирал Б.Дашдаваа нар гэрээнд гарын үсэг зурж баталгаажууллаа.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
НЭРЭМЖИТ СПОРТЫН 5 ТӨРӨЛТ ТЭМЦЭЭНИЙ
ШИЛЖИН ЯВАХ ЦОМЫН ЭЗНЭЭР ЦАХИЛГААН
ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК ТОДОРЛОО

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн нэрэмжит “ШИЛЖИН ЯВАХ ЦОМ”-ын төлөөх спортын 5 төрөлт тэмцээн 2023 оны 05 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд амжилттай болж өндөрлөлөө. Тэмцээний нийлбэр дүнгээр Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн баг тамирчид тэргүүлж “ШИЛЖИН ЯВАХ ЦОМ”-ын эзнээр тодорлоо.

ДАМЖУУЛАХЫН ЗАЛУУС ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА
БАЙГУУЛЛАА

2023 оны 06-р сарын 08-ны өдөр компанийн ерөнхий инженер б. Эрхэмзаяагийн санаачилгаар “Дамжуулахын залуус” гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллагыг залуучуудын оролцоотойгоор үүсгэн байгууллаа. Энэ өдөр залуучуудын чуулган уулзалтыг танхимын болон цахимаар зохион байгуулсан бөгөөд Төв удирдлагаас 8, Улаанбаатар салбараас 15, Төвийн бүсийн салбараас 8, Хангайн бүсийн салбараас 8, Зүүн-Өмнөд бүсийн салбараас 8, Говийн бүсийн салбараас 8 ИТА, мэргэжилтнүүд оролцож, байгууллагын үндсэн дүрмийг хэлэлцэн баталж, бүрэлдэхүүнийг сонгосон юм. Тухайлбал, “Дамжуулахын залуус” ТТБ-ын Тэргүүнд Төв удирдлагын Бизнес төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Төлөвлөлтийн эдийн засагч Г.Тунгалагтамир, УБС-ын РХАХТА-ны ахлах бөгөөд РХА-ийн инженер Д.Төмөр-Очир нар нэрээ дэвшүүлж 51%-ийн саналаар Д.Төмөр-Очир тэргүүнээр сонгогдсон. Дамжуулахын залуус ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүнд салбар зөвлөлийн дарга нар дүрэмд заасны дагуу шууд орох эрхтэй ба үлдсэн 5 гишүүнд 13 нэр дэвшигчид өрсөлдсөнөөс дараах бүрэлдэхүүн сонгогдсон.

Удирдах зөвлөлийн гишүүд:

ТУ	Г.Тунгалагтамир БТСХ Ш.Аюурзана МТХ /Салбар зөвлөлийн дарга/
УБС	Б.Буяннэмэх /Салбар зөвлөлийн дарга/
ТБС	Т.Хаш-Эрдэнэ /Салбар зөвлөлийн дарга/ Д.Түвшиндорж
ХБС	С.Мөнх-Эрдэнэ Ч.Анхдаваа /Салбар зөвлөлийн дарга/
ЗӨБС	С.Зоригтбаатар /Салбар зөвлөлийн дарга/ Б.Мягмарсүрэн
ГБС	О.Дөлгөөн /Салбар зөвлөлийн дарга/ Х.Эрдэнэсүх

Дамжуулахын залуус ТББ-ын Хариуцлагын зөвлөлийн гишүүнд 7 ажилтны нэрийг дэвшүүлсэн ба тэдгээрээс дараах ажилтнууд сонгогдсон.


Хариуцлагын зөвлөлийн гишүүд:

УБС	Б.Мөнхбадрал
ТБС	Б.Батням
ГБС	П.Лхагвасүрэн

Мөн Дамжуулахын залуус ТББ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар Төв удирдлагын Мэдээлэл технологийн хэлтсийн Программист инженер Б.Баярмаа сонгогдлоо. Дамжуулахын залуус ТББ-тай холбогдохыг хүсвэл дараах хаягаар цахим шуудан илгээх боломжтой.

И-мэйл: damjuulakh.zaluus@gmail.com





ЦДҮС ТӨХК-ИЙН УЛААНБААТАР САЛБАРЫН АЖИЛЧИД МОД ТАРИЛАА.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох ажлын хүрээнд “Ногоон хот-Иргэний оролцоо” 2023 оны хаврын мод тарих, арчлах арга хэмжээ 2023.05.12-2023.05.16-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Тус арга хэмжээнд “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Улаанбаатар салбарын ажилчид оролцож 2023.05.15-ны өдөр “Шинэ-Налайх” цэцэрлэгт хүрээлэнд 5 ширхэг гацуур мод суулгасан.



ЦДҮС ТӨХКОМПАНИЙН МТХ-Н ПРОГРАММ АШИГЛАЛТЫН ИНЖЕНЕР Б.БОЛОРМАА MONGOLIAN OPEN – 2023, ONE-80 ULAANBAATAR OPEN – 2023 ТЭМЦЭЭНҮҮДЭД ТЭРГҮҮН БАЙР ЭЗЭЛЛЭЭ

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод 5-р сарын 25-28-ны өдрүүдэд Дэлхийн дартын холбооны WDF Mongolian open - 2023, One-80 Ulaanbaatar open - 2023, PDC Asia Tour 13-15 цуврал гэсэн Монгол, Хятад, Япон, Солонгос, Сингапур, Энэтхэг, Хонгконг гэсэн 7 улсын 200 гаруй тамирчид өрсөлдсөн олон улсын тэмцээн анх удаа зохион байгуулагдаж өндөрлөлөө. ЦДҮС ТӨХКомпанийн МТХ-н программ ашиглалтын инженер Б.Болормаа нь Mongolian open – 2023 тэмцээнд тэргүүн байр, Мөн One-80 Ulaanbaatar open – 2023 тэмцээнд тэргүүн байр эзэллээ.

Б.Болормаа нь 2023 оны улсын аваргын мөнгөн медаль, БНХАУ-ын Бээжин хотноо "The 9th Capital Darts tournament" тэмцээнээс багийн мөнгөн медаль, Mongolian open – 2023 тэмцээнд тэргүүн байр, One-80 Ulaanbaatar open – 2023 тэмцээнүүдэд тэргүүн байр эзэлснээр Олон улсын хэмжээний мастерын болзлыг хангалаа.

Мөн 2023 оныг чансаагаараа тэргүүлж байгаа учраас Дани Улсад 2023 оны 9 дүгээр сарын 26-30-ны өдрүүдэд зохиогдох Дэлхийн дартын холбооны /WDF/ 23 дахь удаагийн Дэлхийн Цом /World Cup/ тэмцээнд оролцох эрхээ аван Монгол Улсын шигшээ багт орж явах болсон.



УЛААНБААТАР САЛБАРЫН ХАМТ ОЛОН ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ХҮҮХДҮҮДЭД БЭЛЭГ ИЛГЭЭВ

Улаанбаатар салбарын хамт олон нийгмийн хариуцлагын хүрээнд олон улсын “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрийн зорилтот бүлгийн хүүхдүүдэд бэлэг бэлтгэж, 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдөр тус хорооны Засаг даргад хүлээлгэн өгсөн. Бэлэг бэлтгэх санхүүгийн эх үүсгэрийг Улаанбаатар салбарын хамт олон хувийн зүгээс хандивласан.



“ДЦС-3” ТӨХК-ИЙН 55 ЖИЛИЙН ОЙН НЭРЭМЖИТ ЭРЧИМ ХҮЧНИЙ УДИРДАХ АЖИЛТНУУДЫН НӨХӨРСӨГ ТЭМЦЭЭН БОЛЛОО

2023 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр “ДЦС-3” ТӨХК-ийн 55 жилийн ойн нэрэмжит эрчим хүчний удирдах ажилтнуудын гар бөмбөгийн нөхөрсөг тэмцээн ЦДҮС ТӨХК-ийн спорт цогцолборт амжилттай болж өндөрлөлөө. Энэхүү тэмцээнд Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн баг тамирчид тэргүүн байр эзэллээ.



ӨНДӨР ХҮЧДЭЛИЙН ХАМГААЛАЛТЫН ЗУРВАСТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ЖОЛООЧ НАРТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ.

2023.05.08-ны өдөр Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Хяналт мониторингийн хэлтэс, Улаанбаатар салбарын техникийн инженерүүд хамтран өндөр хүчдэлийн хамгаалалтын зурваст үйл ажиллагаа явуулдаг хүнд даацын машин механизмын жолооч нарт сургалт зохион байгууллаа. Тус сургалтад “Гурвалжингийн гүүр”-ний баруун талд байрлах талбай болон “Хос бэрс” захын өмнө үйл ажиллагаа эрхэлдэг 50 гаруй жолооч нарыг хамруулсан.



ЦДҮС ТӨХК-ИЙН 2023 ОНЫ II УЛИРЛЫН АВААР ЭСЭРГҮҮЦЭХ ДАСГАЛ

Улаанбаатар салбарт 212-р АШ-н үндсэн хамгаалалт ажиллаж, таслуур татгалзсан үед ИХБ-4-т 220 кВ-н II СШ-н УРОВ болон Сонгино д/ст-д 220 кВ-н II СШ-н УРОВ, АТ-2-н 110 кВ-н таслуур МТЗ хамгаалалтаар тасарсан үед авах арга хэмжээ сэдвээр ШЗХ-н дарга Чинзаяа, диспетчер инженер Б.Батжаргал, Б.Ариунболд, Ц.Базарваань нар зохион байгуулж явууллаа.


Уг дасгалд Улаанбаатар салбарын диспетчер, ИХБ-4, Сонгино, Телевиз, Найрамдал, Ташгай, Арцат дэд станцуудын шуурхай ажиллагааны нийт 50 ажилтан хамрагдсан. АЭД-ийн үед Сонгино дэд станцын ажилтан мэдээллийг дутуу, алдаатай өгснөөр аваарийг удаашруулах үндсэн шалтгаан болсон.

Дасгалд оролцсон шуурхай ажиллагааны бүх ажилтнаас НСД, ТАД, ААД, Нэгдсэн сүлжээнд гарсан аваар устгах зааврын эмхэтгэлүүдээс бүрдсэн тестээр шалгалт авч, сэлгэн залгалтын хуудас бичүүлж шалгасан.

Сэлгэн залгалтын хуудас бичүүлэхэд РХА-н хоёрдогч хэлхээний болон анхдагч хэлхээний үйлдлүүд дутуу, тоноглолын нэршил стандартын дагуу биш, техникийн болон аюулгүй ажиллагааны арга хэмжээ дутуу, нэр хаягийг андуурсан зэрэг нийтлэг гаргасан алдаануудыг гаргаж байсан ба зарим инженер монтерууд нь сэлгэн залгалтын хуудасныхаа агуулгыг ойлгохгүй, бичигдсэн хуудас нь аваар үүсгэхээр үйлдэл бичигдсэн зэрэг олон дутагдлууд илэрсэн.

Иймд дээрх дасгал болон шалгалтад хангалтгүй дүн үзүүлсэн шуурхай ажиллагааны ажилтнуудад арга хэмжээ тооцох, алдаа дутагдлыг дахин гаргахгүй байхад анхаарч, сургалт дадлагуулалтыг чанартай хийх шаардлагатай байна.

АЭД-ын дараа гарсан алдаа дутагдлын талаар хэлэлцүүлэг хийж сургалт зохион байгууллаа.



“НЭГЭН ЖАРНЫ ТҮҮХ”

БУЛАН

ТАЙЛБАР: Монгол Улсад цахилгаан дамжуулах сүлжээ үүсэж хөгжсөний нэгэн жарны түүхэн ой 4 жилийн дараа тохиох болно. Түүхийн үйл явцтай холбогдуулан Дамжуулах сүлжээ сонинд “НЭГЭН ЖАРНЫ ТҮҮХ” буланг Ахмадын хорооноос шинээр нээж техникийн дэвшил, түүнийг эзэмшигч хөдөлмөрийн хүмүүсийн тухай дугаар дараалан хамт олноо толилуулахыг зорьж байна.

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭНИЙ БА ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМИЙН ҮҮСЭЛ (ЦУВРАЛ-2)

БНМАУ-ын “Улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх 1960-1965 оны төлөвлөгөө”-д эрчим хүчийг хөгжүүлэх тухай зорилт амжилттай хэрэгжиж Улаанбаатар хотод 12 МВт-ын Толгойтын дулааны цахилгаан станцыг (1961.12.26) ашиглалтад оруулж, 36 МВт-ын Төв цахилгаан комбинат (1963.02.26) тав дахь удаагийн өргөтгөл хийгдэж, 35/6 кВ-ын ил хуваарилах байгууламж шугамын хамт баригдан Толгойтын дулааны цахилгаан станцын 35/6 кВ-ын өндөр талтай (1964.08.24) холбогдсоноор Монгол Улсад анх удаа хоёр цахилгаан станц зэрэгцээ ажиллаж, Эрчим хүчний систем үүсэх эхлэл тавигдсан.

Дархан хотод 48 МВт-ын дулааны цахилгаан станцын эхний ээлж, Дархан-Сүхбаатарын 103 км 110 кВ-ын цахилгаан дамжуулах шугамыг 35 кВ-ын хүчдэлээр залган (1965.06.15) 110 кВ-ын ажлын хүчдэлээр ашиглаж (1965.11), Сүхбаатар-Дархан-Шарын гол-Зүүнхараа-Борнуур-Улаанбаатарын 110 кВ-ын 392 км цахилгаан дамжуулах шугам (1965.12.08) баригдаж дууссан. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 155 дугаар тогтоолын дагуу шинээр ашиглалтад орсон өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах сүлжээний ашиглалт, үйлчилгээг хариуцахаар Аж үйлдвэрийн яамны харьяа Дархан-Сэлэнгийн цахилгаан шугам сүлжээний газар (1965.04.01), Сайд нарын Зөвлөлийн 154 дүгээр тогтоолоор Цахилгаан ашиглалт, монтажийн газраас гэрэл борлуулах үйл ажиллагааг тусгаарлаж, Улаанбаатарын цахилгаан шугам сүлжээний газар (1965.05.12)-ыг тус тус байгуулсан.

Улаанбаатар-Хонхор-Налайхын 35 кВ-ын төмөр баганат хос шугам (1966.10.25), Дархан хотын дулааны цахилгаан станц бүрэн хүчин чадлаараа (1966.01.15) ашиглалтад тус тус орж, Дархан-Улаанбаатарын 110 кВ-ын цахилгаан дамжуулах шугамаар Улаанбаатар хотын дулааны гуравдугаар цахилгаан станцын ил хуваарилах байгууламжид 35 кВ-ын хүчдэл (1967.06.30) өгснөөр 110 кВ-ын ажлын хүчдэлээр залгагдан (1967.07.05) Улаанбаатар хотод дулааны цахилгаан станц I ба II, Сэлэнгэ аймагт Сүхбаатарын дулааны цахилгаан станцуудтай зэрэгцээ ажилласнаар Төвийн эрчим хүчний системийн эхлэл тавигдан Диспетчерийн албыг шинээр байгуулж төвлөрсөн удирдлагаар хангах болов. УБЦШСГ-ын даргаар Д.Нанзад, ерөнхий инженерээр Д.Жигжид (МЭИ), Үйлдвэр техникийн хэлтсийн даргаар Б.Нүүрэй, 35-110 кВ-ын дамжуулах сүлжээний цехийн даргаар Л.Бямба (Харьковын ХАА Академи), Хуваарилах сүлжээний цехийн даргаар Ц.Батнасан, Диспетчерийн албаны даргаар Ш.Пүрэв (Киевийн Политехникийн институт) нар томилогдож байсан. Сайд нарын Зөвлөлийн 204 дүгээр тогтоолоор Дархан-Улаанбаатарын 110 кВ-ын шугамын ашиглалтыг УБЦШСГ хариуцах болж Үйлдвэр техникийн хэлтэс болон Зүүн-Хараагийн салбарыг (1967.12.01) Зүүнхараа хотод тус тус байгуулж, ерөнхий инженерээр С.Болдыг томилон ажиллуулсан.

ДСЦШСГ-ын даргаар н.Жадамбаа, ерөнхий инженерээр Г.Өлзийбат (Киевийн Политехникийн дээд сургууль), эдийн засагчаар Ц.Уламбаяр (МУИС), Ашиглалтын цехийн даргаар Ц.Баасандорж (МУИС), инженерээр А.Сонинбаатар, Ё.Дондог (МУИС), Шарын голд Н.Батсүх нар Түлш, эрчим хүчний үйлдвэр, геологийн яамнаас хуваарилагдан очиж, ажиллаж байсан. Ашиглалтын цех, Санхүү, эдийн засгийн хэсэг, лаборатори, Захиргаа, аж ахуй, Гэрэл борлуулах тасаг зэрэг нэгжтэй, Ашиглалтын цехэд Өмнөд, Хойд, Сүхбаатар дэд станцууд, 110 кВ-ын шугам, Шарын голын 35 кВ-ын шугам хамрагдаж, Шарын голын дэд станцыг 110 кВ-ын хүчдэлд шилжүүлэхэд хүчдэл өндөржилтөөс хамгаалах схемийг инженер Ё.Дондог, Д.Нанжаа нарын боловсруулсан төхөөрөмжийг тавьж, Давхар, Орхон, Борнуур дэд станцад 35 кВ-ын нум унтраагч төхөөрөмж суурилуулж байв. 1970 онд Дархан-Ерөө-Бугант, Орхоны 110 кВ-ын шугам, дэд станцууд ашиглалтад орсноор ДСЦШСГ-ын үйлчилгээний хүрээнд Сүхбаатар, Дулаанхаан, Дарханы Давхар, Бурхант, Шарын голын уурхайн 110 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, 110/6 кВ-ын дэд станцууд, түүний 6 кВ-ын хуваарилах сүлжээ зэрэг орсон байв. Шугам, тоноглолын техникийн ашиглалт, өндөр хүчдэлийн туршилтын лаборатори, Засварын цех, авто механизмын гараж, диспетчерийн удирдлагын пульт бүхий нэгдсэн удирдлагын байр (одоогийн ЦДҮС ТӨХК-ийн Төвийн бүсийн салбар) хамт ашиглалтад оржээ. Монгол Улсын Засгийн газрын 164 дүгээр тогтоолоор (2001.08.01) Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК-ийн Дархан-Сэлэнгийн салбар нь 5 нэгж, 120 ажилтантай зохион байгуулалтад шилжиж, даргаар Ц.Чулуунбаатар, ерөнхий инженерээр С.Болд, ахлах нягтлан бодогчоор С.Тогоосүрэн нарыг томилон ажиллуулж, Засгийн газрын 108 дугаар тогтоолоор (2012 он) Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Төвийн бүсийн салбараар нэрших болов.

БНМАУ, Зөвлөлт Холбоот Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэрийн харьяанд 310 Гкал/цаг суурилагдсан хүчин чадалтай 435С хэмийн, 39 ата даралтын цагт 75 тонн уур үйлдвэрлэх дулааны цахилгаан станц (1975.11) ашиглалтад орж, уулын баяжуулах үйлдвэр, Эрдэнэт хотыг бүхэлд нь дулаанаар хангаж эхлэв. “Эрдэнэтийн овоо” ордыг түшиглэсэн шинэ үйлдвэр нь жилд 26 сая тонн хүдэр боловсруулж 530.0 орчим мянган тонн зэсийн, 4.5 орчим мянган тонн молибдены баяжмал боловсруулах хүчин чадалтай, цахилгааны ачаалал нь 100 МВт хүрэх тооцоотой байсан тул

улс хоорондын цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн 220 кВ-ын хос хэлхээт “Селендум-Дархан” шинэ шугамыг барьж, ашиглалтад оруулснаар ЗХУ-ын Сибирийн эрчим хүчний нэгдсэн системтэй Монгол Улсын Төвийн эрчим хүчний систем (1976.12.30) зэрэгцээ ажиллагаанд холбогдсон түүхтэй. Дархан 220/110/35 кВ-ын 2х63 мВА дэд станцад улс хоорондын 257, 258 дугаар шугамын тусгаарлагч автоматикийг инженер Ё.Дондог, ТЭХС-ийн инженер Д.Нанжаа нар тохируулан суурилуулсан нь олон жил үүргээ гүйцэтгэж, эх орны эрчим хүчний системийн тогтвортой ажиллагааг хангасан байна. Дархан-Эрдэнэтийн 220 кВ-ын хос шугам, 220/110/35 кВ 2х125 мВА дэд станцыг ЗХУ-ын болон Монгол Улсын эрчим хүчний барилгачид угсран 1976 онд 110 кВ-ын түр хүчдэлээр, 1978 онд 220 кВ-ын ажлын хүчдэлээр ажиллагаанд оруулсан. Эрдэнэт дэд станцаас Булган аймгийн төвийг 110 кВ-ын шугамаар 1979 онд хангах болсон нь эх орны Хангайн бүс нутгийг Төвийн эрчим хүчний системээс цахилгаан эрчим хүчээр хангах эхлэл тавигджээ.

Мэдээллийг бэлтгэсэн: ЦДҮС ТӨХК-ийн Ахмадын хорооны дарга
Монгол Улсын Аж үйлдвэрийн гавьяат ажилтан
Зөвлөх инженер Л.Дарамбазар

Булган-Хархорин чиглэлд унасан 24 ширхэг тулгуурыг түргэн шуурхай сэргээн засварлаж цахилгаан эрчим хүчинд холбосон ЦДҮС ТӨХК-ийн хамт олонд “Диспетчерийн үндэсний төв”-өөс ирүүлсэн талархлыг уншигчиддаа уламжилъя.



“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН НИЙТ ХАМТ ОЛОНД

Булган-Хархорин чиглэлийн 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамд байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэмтэл гарч 24 тулгуур унаж 6 аймгийн 80 гаруй сум, суурин газар эрчим хүчээр хязгаарлагдаад байгаа билээ.

Энэ цаг үед танай компанийн удирдлага, инженер, техникийн ажилчид шуурхай зохион байгуулалтад орж, яаралтай арга хэмжээг авч хэрэгжүүлэн гэмтэл саатлыг цаг алдалгүй сэргээн засварлаж хэрэглэгчдийн тасралтгүй, найдвартай эрчим хүчээр хангах салбарын чиг үүргийг хэрэгжүүлэхээр хүндрэл бэрхшээлийг даван ажиллаж байгаад бид бүхэн бахархаж байна.

Мэргэжлийн удирдлага, ажилтнуудын ур чадвар, хариуцсан ажилдаа хоёргүй сэтгэлээр зүтгэдэг танай компанийн хариуцлагатай, чадварлаг ажилтнуудын олон цагийн шаргуу хөдөлмөрийн үр дүнд тус гэмтлийг богино хугацаанд арилгасан явдалд талархал илэрхийлж байна.

Энх цагийн эгэл баатрууд болсон танай компанийн эрхэм хүндэт мэргэжил нэгт нөхөд, нийт хамт олонд нь эрчим хүчний салбарын түүхт 100, 101 жилийн ойн баярын мэндийг хүргэж ажлын амжилт, нийт гэр бүлд нь эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Ган судсаар холбогдсон эрчим хүчний салбар үүрд мандан бадрах болтугай.

ДИСПЕЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨХК-ИЙН НИЙТ ХАМТ ОЛНООС,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Эрхлэн гаргасан: захиргаа удирдлагын хэлтсийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн Д.Энхбаяр